



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2012 оны 03 сарын 29 өдөр

Дугаар 98

Улаанбаатар хот

**Журам батлах тухай**

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7.2, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж байгууллагад дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 1.3 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн яамны үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.
2. Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргад даалгасугай.

САЙД



Н.ХҮРЭЛБААТАР

Эрүүл мэндийн сайдын 2012 оны  
98 тоот тушаалын хавсралт



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД  
ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫГ  
ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ**

**1. Зорилт**

1.1. Энэхүү журмын зорилго нь Эрүүл мэндийн яамны хэмжээнд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, сахилга дэг журмыг бэхжүүлэх, авлига, хүнд суртлаас урьдчилан сэргийлэх, аппаратын үйл ажиллагааг хөнгөн шуурхай явуулах, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэхэд оршино.

**2. Дотоод хяналт шалгалтын хамрах хүрээ**

- 2.1. Дотоод хяналт шалгалтад дор дурдсан үйл ажиллагааг хамруулна.
  - 2.1.1. Худалдан авах ажиллагаа
  - 2.1.2. Төрийн өмчийн бүртгэл, тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалт
  - 2.1.3. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ олголт
  - 2.1.4. Шагнал урамшил олголт
  - 2.1.5. Тус яаманд ажилд орох хүсэлт гаргасан иргэнийг хүний нөөцөд авах, тодорхой албан тушаалд томилсон байдал
  - 2.1.6. Хууль, УИХ, Засгийн газрын тогтоол нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон журам, дүрмийн төсөл боловсруулалт
  - 2.1.7. Яамны "Нууц"-тай холбоотой баримт бичигт тавих хяналт
  - 2.1.8. Тамга тэмдэг түших ажиллагаа
  - 2.1.9. Гадаад албан паспорт олголт
  - 2.1.10. Албан хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлэг хадгалалт, хяналт
  - 2.1.11. Яамны үйл ажиллагааны төлөвлөгөө, Засгийн газрын хуралдаан, Сайдын зөвлөл, Удирдлагын зөвлөлийн хурлын төлөвлөгөөний хэрэгжилт
  - 2.1.12. Яамны ажилтны цалин хөлс бодолт, санхүүжилт, төсвийн гүйцэтгэл
  - 2.1.13. Яамны дотоод журмын хэрэгжилт

**3. Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах зарчим**

3.1. Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулахад төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасан хууль дээдлэх, хараат бус, шударга ёсыг хангах, ил тод, бодитой, байх зарчмыг баримтална.

**4. Дотоодын хяналт шалгалтын зохион байгуулалт, ажилтны эрх үүрэг**

4.1. Яамны дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах үүргийг Яамны "Дотоод хяналт шалгалт хариуцсан" ажилтан, комисс гүйцэтгэнэ.

4.2. Дотоод хяналт шалгалтын хариуцсан ажилтан нь Яамны байгууллагын удирдлагад шууд захирагдах бөгөөд зохион байгуулалтын хувьд бусад бүтэц, нэгжээс хараат бус байна.

4.3. Дотоод хяналт шалгалтын ажилтан нь тухайн аж ахуйн нэгж, байгууллагын эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлээр боловсрол, мэргэжил эзэмшиж мэргэшсэн, ажлын дадлага туршлагатай байна.

3.4. Дотоод хяналт шалгалтын ажилтан нь Яамны үйл ажиллагааны онцлог, зохион байгуулалтын бүтэц, харьяалагдах нэгж, объектын тоог харгалзан тухайн жилд хийх хяналт шалгалтын ажлын тусгайлсан төлөвлөгөөг боловсруулан эрх бүхий албан тушаалтнаар батлуулан мөрдөж ажиллана.

3.5. Дотоод хяналт шалгалтын ажилтан нь хяналт шалгалтын ажлын дүн, авсан арга хэмжээний талаар улиралд нэгээс доошгүй удаа Удирдлагын завлалийн хурлаар хэлэлцүүлж, шаардлагатай бол шийдвэр гаргуулан хамт олонд мэдээлнэ.

3.6. Дотоод хяналт шалгалтын ажилтан нь эрх бүхий албан тушаалтны баталсан удирдамжийн дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэнэ.

4.4. Дотоод хяналт шалгалтын ажилтан нь дараахь эрх, үүрэгтэй байна:

4.4.1. зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэж, дүнг тайлагнах;

4.4.2. хяналт шалгалт явуулахдаа байгууллагын салбар, нэгжийн удирдлагатай шууд харилцаж, тэдгээрээс шаардлагатай мэдээ, судалгаа гаргуулах, холбогдох ажилтны ажлыг шалгаж танилцах, илэрсэн зөрчил, дутагдлын талаар тайлбар гаргуулах;

4.4.3. илэрсэн зөрчил, дутагдлын шалтгаан нөхцөлийг тодруулан зөрчлийг арилгуулах, дахин гаргуулахгүй байх талаар арга хэмжээ авах;

4.4.4. шаардлагатай бол илэрсэн зөрчил, дутагдлын шалтгаан нөхцөлийг арилгах асуудлаар болон зөрчил гаргасан этгээдэд хариуцлага ногдуулах талаар байгууллагын удирдлагад санал тавьж шийдвэрлүүлэх;

4.4.5. хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актыг өөрийн байгууллагад сурталчлах, хэрэгжүүлэх талаар сургалт зохион байгуулах;

4.4.6. хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгах, урьдчилан сэргийлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх;

4.4.7. холбогдох дүрэм, журам, байгууллагын стандартыг боловсронгуй болгох талаар судалгаа, дүгнэлт гаргах;

4.4.8. дотоод хяналт шалгалтын үр нөлөө болон мэргэжлийн чадавхийг дээшлүүлэх зорилгоор хөндлөнгийн хяналтын байгууллагаас мэргэжил арга зүйн зөвлөгөө авах, зөрчлийг нь арилгаж чадахгүй асуудлыг хууль хяналтын эрх бүхий

байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, хамтран ажиллах талаар санал боловсруулан удирдлагад танилцуулах;

4.4.9. байгууллагын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэл, холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандартын хэрэгжилт болон зөрчлийн талаархи мэдээллээр удирдлагыг хангах;

4.4.10. хийсэн хяналт шалгалтын талаар бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх;

4.5. Энэхүү журмын 4.4-д заасан эрх, үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дотоод хяналт шалгалтын ажилтанд аливаа дарамт, шахалт үзүүлэх, үйл ажиллагаанд нь хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно.

4.6. Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах комиссыг энэ журмын 2.1-д заасан үйл ажиллагааны чиглэл, онцлогийг харгалзан Төрийн нарийн бичгийн дарга тухай бүр байгуулна.

4.7. Дотоод хяналт шалгалтыг төлөвлөгөөт болон гэнэтийн гэсэн хоёр хэлбэрээр зохион байгуулна.

4.8. Дотоодын хяналт шалгалт хийх төлөвлөгөөг тухайн оны эхний сард багтаан төрийн нарийн бичгийн дарга батална.

4.9. Дотоодын хяналт шалгалт хийхээр томилогдсон комисс нь хяналт шалгалт явуулахдаа байгууллагын нэгжийн удирдлагатай шууд харилцаж, тэдгээрээс шаардлагатай мэдээ, судалгаа гаргуулан танилцах, холбогдох ажилтны ажлыг шалгаж танилцах, илэрсэн зөрчил дутагдлын талаар тайлбар гаргуулах, зөрчил дутагдлын шалтгаан нөхцөлийг арилгах талаар байгууллагын удирдлагад санал оруулах эрх эдэлнэ.

## **5. Дотоод хяналт шалгалтын дүн, хариуцлага**

5.1. Хийгдсэн хяналт шалгалтын дүн, авсан арга хэмжээний тухай Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, шаардлагатай бол зохих шийдвэр гаргаж хамт олонд мэдээлнэ.

5.2. Дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын дагуу буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомж, тухайн аж ахуйн нэгж, байгууллагын дотоод журамд заасан хариуцлагыг ногдуулна.

5.3. Дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал нь гэмт хэргийн шинжтэй бол асуудлыг хуулийн байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.